## ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ ....................1
1.1 Төслийн ерөнхий мэдээлэл ....................1
1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл....................1
1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт ....................1
1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт ....................3
1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт ....................5
1.2.1 Ордын нөөц ....................5
1.2.2 Ордын уул техникийн нөхцөл ....................6
1.2.3 Ил уурхайн жилийн хүчин чадал, ашиглалтын хугацаа....................6
1.2.4 Ил уурхайн ажиллах горим ....................6
1.2.5 Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө....................7
1.2.6 Шимт хөрсний овоолго ....................8
1.2.7 Хөрсний овоолго....................8
1.3 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц ....................9
1.4 Уурхайн тоног төхөөрөмж ....................9
1.4.1 Уулын үндсэн техник, тоног төхөөрөмж ....................9
1.4.2 Туслах ажлын механикжуулалт ....................9
1.4.3 Өрөмдлөг, тэсэлгээ ....................10
1.5 Дэд бүтэц ....................10
1.5.1 Уурхайн барилга байгууламж ....................10
1.5.2 Цахилгаан хангамж ....................11
1.5.3 Дулаан хангамж ....................11
1.5.4 Усан хангамж ....................11
1.6 Төслийн эцсийн бүтээгдэхүүн ....................12
1.6.1 Элементийн шинжилгээ, металлын баланс....................12
2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ....................13
2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт ....................13
3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ....................16
4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ....................17
5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....................23
6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....................27

7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....................28
8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ ....29
9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ....................31
10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ ....................33
11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР ....................35
12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ....................39
13. ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ..........41

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбицол....2
Хүснэгт 2. Төслийн нэгжийн ажлын горимууд, гол гол ажлын байруудаар....4
Хүснэгт 3. Ордын нөөцийн тооцооны хүснэгт (Ордын нөөц 2024-01-01-ий өдрийн байдлаар)....5
Хүснэгт 4. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс....6
Хүснэгт 5. Уурхайн ажлын горим....6
Хүснэгт 6. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө....7
Хүснэгт 7. Шимт хөрсний овоолгын хэмжээ....8
Хүснэгт 8. Хөрсний овоолгын параметр....8
Хүснэгт 9. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж....9
Хүснэгт 10. Уурхайн туслах тоног төхөөрөмж....9
Хүснэгт 11. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт....13
Хүснэгт 12. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал....16
Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....17
Хүснэгт 14. ТЭЗҮ-д тусгасан нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлт....23
Хүснэгт 15. 2026 онд хийж гүйцэтгэхээр ТЭЗҮ-д тусгасан ажлын төлөвлөгөө.....24
Хүснэгт 16. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө....29
Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө....31
Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө....33
Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр....35
Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө....39
Хүснэгт 21. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь....41

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг....2
Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг....3
Зураг 3. Овоолгын төлөвлөлт....8
Зураг 4. Хөрсний овоолгын байршлын төлөвлөлтийн зураг....9
Зураг 5. Шимт хөрсний төлөвлөлт болон өнөөгийн төрх байдал....26
Зураг 6. Нөөлөллийн тархалтийн хэмжээ болон дүйцүүлэн хамгаалах боломжит газрын байршил....27
Зураг 7. Төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж буй Мониторингийн цэг....38

# 1. ТӨСЛИЙН ТОДОРХОЙЛОЛТ

## 1.1 Төслийн ерөнхий мэдээлэл

### 1.1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн тухай товч мэдээлэл

| | |
|---|---|
| ***Төслийн нэр :*** | Гурван хүлэгт нэртэй хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах |
| ***Төсөл хэрэгжүүлэгч :*** | Билгэх сайхан уул” ХХК,<br>Улсын бүртгэлийн дугаар: 9011853120<br>Регистрийн дугаар: 8374007<br>Тусгай зөвшөөрлийн дугаар : MV-022839<br>Захирал: Ц.Ганзориг<br>Утас: 99115052 |
| ***Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг:*** | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 3-р хороо, Хос өргөө хотхон, 29а, 41 тоот |

**Үндсэн үйл ажиллагаа.** “Билгэх сайхан уул” ХХК нь Улсын бүртгэлийн гэрчилгээгээр 7490 кодтой “Ашигт малтмал ашиглах” үндсэн үйл ажиллагаатай.

**Ашигт малтмалын нөөцтэй холбоотой баримт бичгүүд.**

- Билгэх-3 нэртэй ордын нөөцийг 2024 оны 9-дүгээр сарын 05-ны Үндэсний геологийн албаны даргын Н/81 тоот ашигт малтмалын нөөцийн улсын нэгдсэн санд бүртгүүлсэн тушаал
- Билгэх-3 нэртэй ордын нөөцийн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлсэн 2024 оны 07-дугаар сарын 05-ны өдрийн АМГТГ-ын эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ХХ-10-05 тоот дүгнэлт

### 1.1.2 Төслийн байршил, газар ашиглалтын тодорхойлолт

Гурван хүлэгт” хайлуур жоншны орд нь Улаанбаатар хотоос 380 км, Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт, сумын төвөөс зүүн тийш 22 км зайд Дэрсэнэ-Ус багийн нутагт MV-022839 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд оршино.




*Зураг 1. Төслийн тусгай зөвшөөрлийн талбайн байршлын зураг*

*Хүснэгт 1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн эргэлтийн цэгийн солбицол*

| Цэг | Уртраг | |
|---|---|---|
| | Градус | Минут |
| 1 | 106°46’21.41” | 45°25’27.36” |
| 2 | 106°47’12.28” | 45°25’8.61” |
| 3 | 106°50’41.46” | 45°24’48.49” |
| 4 | 106°50’41.46” | 45°25’45” |
| 5 | 106°46’21.41” | 45°25’45” |



*Зураг 2. Төсөл хэрэгжих талбайн ерөнхий зураг*

### 1.1.3 Төслийн үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт

**Төслийн удирдлагын нэгж.** Хүний нөөцийн менежментийн хувьд компанийн өөрийн ажиллагсдын үйл ажиллагааг төв оффисоос удирдаж ажиллах бөгөөд хүний нөөцийн удирдлага нь уурхайн ажиллагсдыг сонгон авч, удирдлага ажилтны хоорондох гүүр болж ажиллана.

Компанийн үйл ажиллагааны өдөр тутмын шийдвэр гаргалтыг ерөнхий захирлын алба болох чиг үүрэг хариуцсан бүтэц уурхай дарга, ашиглалт хариуцсан ерөнхий инженер, хангамжийн алба, санхүүгийн хэлтэс, үйлчилгээний хэсэг, хүний нөөцийн алба зэргээс бүрдэнэ.

**Төсөлд шаардлагатай хүний нөөц.** Гурван хүлэгт хайлуур жоншны уурхай нь 300 хоног 2 ээлжээр, ээлжид 12 цаг ажиллаж. Нийт 4 жилийн хугацаанд нийт 81 хүнийг тогтмол ажлын байраар хангана. “Билгэх сайхан уул” ХХК-ийн компанид уурхайн удирдлага зохион байгуулалтын хэсэгт 11 хүн, аж ахуйн хэсэгт 24 хүн тус тус ажиллана. Орон нутгийн иргэдийг сургаж ажилд авах бөгөөд хүний нөөцийн төлөвлөлтийг уурхайн хөдөлмөр зохион байгуулалт, шаардлагатай удирдах болон туслах ажилчдын хэрэгцээнд тулгуурлаж төлөвлөв.




*Схем 1. Уурхайн ажиллах схем*

**Төслийн нэгжийн ажлын горим** Гурван хүлэгт хайлуур жоншны ордын уурхайн хөдөлмөр зохион байгуулалт ВАХТ-ын буюу ажил амралтын горим нь 14/14 (хоног ажиллах 14/14 хоног амрах) системээр ажиллана.

Төслийн хэмжээнд нийт ажлын горим жилд 335 хоногоор дундажлагдаж байгаа нь жилийн хоног ашиглалтаар 93.0 хувьтай байна.

*Хүснэгт 2. Төслийн нэгжийн ажлын горимууд, гол гол ажлын байруудаар*

| № | Хэсэг нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1. | Захиргаа удирдлага | Уурхайн дарга | 1 |
| 2. | | Геотехникийн инженер | 2 |
| 3. | | Ерөнхий инженер | 2 |
| 4. | | Байгаль орчны мэргэжилтэн | 2 |
| 5. | | Геологич | 2 |
| 6. | | ХАБЭА хариуцсан ажилтан | 2 |
| 7. | | Маркшейдер | 2 |
| Дүн | | | **11** |
| 8. | Аж ахуй | Сэлбэг материалын нярав | 2 |
| 9. | | Түлшний нярав | 2 |
| 10. | | Үйлчилгээний жолооч | 4 |
| 11. | | Түлшний машины жолооч | 2 |
| 12. | | Эмч | 2 |
| 13. | | Тогооч | 2 |
| 14. | | Туслах тогооч | 2 |
| 15. | | Үйлчлэгч | 2 |
| 16. | | Галч | 2 |
| 17. | | Харуул, хамгаалалтын ажилтан | 4 |
| **Дүн** | | | **24** |
| 18. | **Ил уурхай** | Уулын мастер | 4 |
| 19. | | Автосамосвалын жолооч | 16 |
| 20. | | Ачигч машины жолооч | 4 |
| 21. | | Бульдозерын жолооч | 4 |
| 22. | | Эксковаторын жолооч | 4 |
| 23. | | Грейдерийн жолооч | 2 |
| **Дүн** | | | **34** |
| 24. | Засвар үйлчилгээ | Механик инженер | 2 |
| 25. | | Цахилгааны инженер | 2 |

| № | Хэсэг нэгж | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 26. | | Засварчин | 2 |
| 27. | | Цахилгаанчин | 2 |
| 28. | | Гагнуурчин | 2 |
| 29. | | Туслах ажилтан | 2 |
| **Дүн** | | | 12 |
| **Нийт дүн** | | | **81** |

## 1.2 Ашигт малтмалын ордын тодорхойлолт

### 1.2.1 Ордын нөөц

Гурван хүлэгт хайлуур жоншны ордод 2022-2024 онд гүйцэтгэсэн хайгуул ажлын үр дүнгийн тайлан /2024 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар/ дахь хайлуур жоншны ордын геологийн нөөцийг бодитой (B) зэрэглэлээр 46.11%-ийн дундаж агуулгатай 102,486.58 тн хүдэрт эрдсээр 47,256.96 тн, боломжтой (C) зэрэглэлээр 50.48%-ийн дундаж агуулгатай 347,301.61 тн хүдэрт эрдсээр 175,331.01 тн нөөц, нийт бодитой болон боломжтой (B+C) зэрэглэлээр 49.49%-ийн дундаж агуулгатай 449,788.20 тн хүдэрт 222,587.97 тн эрдсийн нөөцийг улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлжээ.

*Хүснэгт 3. Ордын нөөцийн тооцооны хүснэгт (Ордын нөөц 2024-01-01-ий өдрийн байдлаар)*

| Хүдрийн | Блокийн дугаар | Блокийн талбай, $м^2$ | Блокийн эзлэхүүн, $м^3$ | Эзлэхүүн жин, $т/м^3$ | Дундаж агуулга, % | Дундаж зузаан, м | Хүдэр, тн | Эрдэс, тн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүдрийн биет-1** | B1 | 838 | 10,925 | 2.68 | 43.36 | 13.04 | 29,299.99 | 12,704.47 |
| | B2 | 2,079 | 18,482 | 2.72 | 48.89 | 8.89 | 50,230.94 | 24,557.91 |
| **Хүдрийн биет-5** | B3 | 834 | 5,954 | 2.67 | 41.90 | 7.14 | 15,909.96 | 6,666.27 |
| **Хүдрийн биет-11** | B4 | 412 | 1,475 | 2.68 | 43.69 | 3.58 | 3,958.77 | 1,729.59 |
| | B5 | 235 | 1,128 | 2.74 | 51.79 | 4.80 | 3,086.92 | 1,598.72 |
| **Бодитой (B) зэрэглэл** | | | | | **46.11** | **7.49** | **102,486.58** | **47.256.96** |
| **Хүдрийн биет-1** | C1 | 761 | 8,287 | 2.71 | 47.52 | 10.89 | 22,449.27 | 10,667.90 |
| | C2 | 900 | 6,489 | 2.80 | 61.97 | 7.21 | 18,187.40 | 11,270.73 |
| | C3 | 520 | 2,163 | 2.71 | 47.13 | 4.16 | 5,854.37 | 2,759.16 |
| **Хүдрийн биет-4** | C4 | 1,116 | 2,734 | 2.53 | 19.52 | 2.45 | 6,909.0 | 1,348.64 |
| **Хүдрийн биет-5** | C5 | 3,211 | 22,927 | 2.67 | 41.90 | 7.14 | 61,267.74 | 25,671.18 |
| **Хүдрийн биет-6** | C6 | 1,761 | 13,401 | 2.81 | 63.34 | 7.61 | 37,680.32 | 23,866.71 |
| | C7 | 1,972 | 8,558 | 2.77 | 57.23 | 4.34 | 23,724.06 | 13,577.28 |
| **Хүдрийн биет-7** | C8 | 1,220 | 1,647 | 2.54 | 22.06 | 1.35 | 4,188.96 | 924.09 |
| **Хүдрийн биет-8** | C9 | 1,166 | 8,617 | 2.79 | 61.14 | 7.39 | 24,051.87 | 14,705.31 |
| **Хүдрийн биет-9** | C10 | 3,262 | 18,006 | 2.71 | 48.41 | 5.52 | 48,793.74 | 23,621.05 |
| | C11 | 2,058 | 9,878 | 2.69 | 45.96 | 4.80 | 26,613.83 | 12,231.72 |
| **Хүдрийн биет-10** | C12 | 1,198 | 2,935 | 2.54 | 22.37 | 2.45 | 7,464.45 | 1,669.80 |
| **Хүдрийн биет-11** | C13 | 912 | 3,757 | 2.70 | 45.92 | 4.12 | 10,139.38 | 4,656.00 |
| | C14 | 1,510 | 9,392 | 2.76 | 55.29 | 6.22 | 25,916.70 | 14,329.34 |

| Хүдрийн | Блокийн дугаар | Блокийн талбай, $м^2$ | Блокийн эзлэхүүн, $м^3$ | Эзлэхүүн жин, т/$м^3$ | Дундаж агуулга, % | Дундаж зузаан, м | Хүдэр, тн | Эрдэс, тн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Хүдрийн биет-12** | C15 | 1,159 | 8,658 | 2.78 | 58.32 | 7.47 | 24,060.52 | 14,032.10 |
| **Боломжтой (С) зэрэглэл** | | | | | **50.48** | **5.54** | **347,301.61** | **175,331.01** |
| **Нийт (B+C) зэрэглэл** | | | | | **49.49** | **6.52** | **449,788.20** | **222,587.97** |

### 1.2.2 Ордын уул техникийн нөхцөл

Ил уурхайгаар хүдрийн биетийн уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, хүдрийн биетийн суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлтийн ажлыг хийсний дараа экскаваторын тусламжтайгаар автосамосвалд ачин, хөрс хуулалтын чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг хүдрийн түр овоолго хүртэл тээвэрлэн байрлуулна.




*Схем 2. Ил уурхайн ашиглалтын технологи*

*Хүснэгт 4. Ил уурхайн ашиглалтын системийн үндсэн хэмжээс*

| № | Ашиглалтын технологийн элементүүд | Хэмжих нэгж | Параметрууд |
|---|---|---|---|
| **1** | Ил уурхайн ажлын доголын өндөр | м | **5** |
| **2** | Ил уурхайн ажлын бус доголын өндөр | м | **10** |
| **3** | Ажлын доголын хажуугийн өнцөг | град | **65** |
| **4** | Ажлын бус доголын хажуугийн өнцөг | град | **65** |
| **5** | Ажлын талбайн өргөн | м | **20-40** |
| **6** | Доголын аюулгүй тавцангийн өргөн | м | **3.5** |
| **7** | Замын өргөн | м | **10-12** |
| **8** | **Уурхайн хажуугийн ерөнхий өнцөг** | **град** | **40-48** |

### 1.2.3 Ил уурхайн жилийн хүчин чадал, ашиглалтын хугацаа

Гурван хүлэгт хайлуур жоншны ордыг ТЭЗҮ-д тусгаснаар ордыг ашиглах хугацаа 4 жил байхаар төлөвлөсөн байна.

### 1.2.4 Ил уурхайн ажиллах горим

*Хүснэгт 5. Уурхайн ажлын горим*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээ |
|---|---|---|---|
| **1** | Жилийн хуанлийн хоног | хоног | 365 |
| **2** | Өвлийн улирлын сул зогсолт | хоног | 30 |
| **3** | Уурхайн жилд ажиллах хоног | хоног | 335 |

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Хэмжээ |
|---|---|---|---|
| 4 | Баяр ёслолын амралт | хоног | 16 |
| 5 | Цаг агаарын саатал | хоног | 5 |
| 6 | Төлөвлөгөөт ба төлөвлөгөөт бус засвар, үзлэг | хоног | 14 |
| 7 | **Жилд ажиллах бодит хоног** | **хоног** | **300** |
| 8 | Хоногт ажиллах ээлжийн тоо | ээлж | 2 |
| 9 | Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа | цаг | 12 |
| 10 | Цаг ашиглалтын итгэлцүүр | - | 0.84 |
| 11 | Ээлжид ажиллах бодит цаг | цаг | 10.0 |
| 12 | **Хоногт ажиллах бодит цаг** | **цаг** | **20.0** |
| 13 | Техникийн бэлэн байдлын итгэлцүүр | - | 0.85 |
| 14 | **Жилд ажиллах бодит цаг** | **цаг** | **5,100** |
| 15 | Уурхайн цагийн хүчин чадал | тн/цаг | 23.5 |
| 16 | **Уурхайн хүчин чадал** | тн/ээлж | 235.0 |
| 17 | | тн/хоног | 470.0 |
| 18 | | **тн/жил** | **120,000.0** |

### 1.2.5 Ил уурхайн уулын ажлын календарчилсан төлөвлөгөө

Тус ордыг ил уурхайн аргаар олборлох бөгөөд ашиглалтын 4 жилийн хугацаанд жилд 120.0 мян.тн хүчин чадалтайгаар олборлоно. Нийт 449.0 мян.тн хүдэр олборлож хаягдал бохирдлыг тооцсоноор 451.5 мян.тн байна.

*Хүснэгт 6. Уулын ажлын календарчилсан төлөвлөгөө*

| № | Үндсэн үзүүлэлт | Хэмжих нэгж | 1-р жил | 2-р жил | 3-р жил | 4-р жил | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Уулын цул | $м^3$ | 742,265.8 | 550,261.4 | 590,839.0 | 600,102.6 | 2,483,468.8 |
| 2 | Хөрс | $м^3$ | 698,363 | 506,464 | 546,781 | 564,689 | 2,316,297 |
| 3 | Жонш | $м^3$ | 43,902.8 | 43,797.4 | 44,058.0 | 35,413.6 | 167,171.8 |
| 4 | | тн | 120,000.0 | 120,000.0 | 120,000.0 | 88,998.8 | 448,998.8 |
| 5 | Хөрс хуулалтын коэффициент | $м^3/тн$ | 5.82 | 4.22 | 6.93 | 6.34 | 5.16 |




*График 1. Ашиглалтын 1-р жил*




*Зураг 3. Овоолгын төлөвлөлт*

### 1.2.6 Шимт хөрсний овоолго

Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3 метрээс ихгүй зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр шууд бульдозероор түрж, утгуурт ачигчаар утган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрсийг уурхайн талбайн гадна 150-170 м зайд байршуулна.

*Хүснэгт 7. Шимт хөрсний овоолгын хэмжээ*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 1 | Ил уурхайн карьер | $м^2$ | 85,246.2 |
| 2 | Хөрсний овоолгын талбай | $м^2$ | 171,809.2 |
| 3 | Тэсрэх материалын агуулахын талбай | $м^2$ | 8,564.2 |
| 4 | Уурхайн кемпийн талбай | $м^2$ | 8,122 |
| 5 | ШТС, засварын газрын талбай | $м^2$ | 6,518 |
| 6 | Нийт авто замын талбай | $м^2$ | 47,933 |
| 7 | Хүдрийн түр овоолгын талбай | $м^2$ | 11,825 |
| **Овоолгын өндөр** | | м | 8.5 |
| **Овоолгын талбай** | | $м^2$ | 12,750 |
| **Овоолгын эзлэх талбай** | | га | 10.2 |
| **Нийт хөрсний хэмжээ** | | **$м^3$** | **102,005.3** |
| **Нийт хөрс хуулах талбай** | | **$м^2$** | **340,017.6** |

### 1.2.7 Хөрсний овоолго

Ил уурхайн хөрсийг өрөмдлөг тэсэлгээний ажлаар сийрэгжүүлж хөрсний гадаад овоолгод хураана. Үндсэн болон агуулагч чулуулгийн шинж чанараас хамааруулан ухаж ачих процессын үр дүнд хөрс нь сийрэгжинэ. Хөрсний гадаад овоолгын байршлыг сонгохдоо тээврийн зайг тооцож, хөрсний овоолгыг ил уурхайн зүүн урд болон урд талд ил уурхайгаас 220-300 м зайд байрлуулахаар тооцов. Чулуулгийн тогтворжилтоос хамааруулж овоолгын доголын өндөр 25 м, доголын хажуугийн өнцгийг 30-33 градус байхаар ТЭЗҮ-д төлөвлөсөн.

*Хүснэгт 8. Хөрсний овоолгын параметр*

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 1 | Овоолгын өндөр | м | 25 |
| 2 | Овоолгын замын өргөн | м | 15 |

| № | Үзүүлэлт | Хэмжих нэгж | Утга |
|---|---|---|---|
| 3 | Овоолгын замын налуу | Промилль | 90 |
| 4 | Овоолгын эзлэх талбай | га | 17.18 |
| 5 | Овоолго дахь хөрсний хэмжээ | мян.м$^3$ | 2,316.3 |




*Зураг 4. Хөрсний овоолгын байршлын төлөвлөлтийн зураг*

## 1.3 Ил уурхайн үйлдвэрлэлийн нөөц

Ил уурхайн хүрээ хязгаар дотор 449.0 мян.тн геологийн нөөц багтах бөгөөд олборлолтын үеийн бохирдлыг 5.0%, ашиглалтын үеийн хаягдлыг 4.23%-аар тус тус тооцсоноор үйлдвэрлэлийн нөөцийн хэмжээ 451.5 мян.тн. Гурван уурхайн нийт эцсийн хүрээнд 2,316.3 мян.м3 хөрс хуулж, хөрс хуулалтын дундаж коэффициент 5.16 м3/тн байна. Уурхайн хүрээн дэх нийт уулын цулын хэмжээ 2,483.5 мян.м$^3$ байна

## 1.4 Уурхайн тоног төхөөрөмж

### 1.4.1 Уулын үндсэн техник, тоног төхөөрөмж

Уулын ажилд хэрэглэх үндсэн техник, тоног төхөөрөмжүүдийг тус ил уурхайн талбай дээр байгаа техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглана. Мөн шаардлагатай техник тоног төхөөрөмжийг нэмж авна. Уурхайд дараах нэр төрлийн техникүүд ажиллана. Үүнд:

*Хүснэгт 9. Уурхайн үндсэн тоног төхөөрөмж*

| Тоног төхөөрөмж | Тоног төхөөрөмжийн марк | Нэгж | Тоо, ширхэг |
|---|---|---|---|
| **Өрмийн машин** | JK730-3 | | 3 |
| **Автосамосвал** | Howo -7 | 22 м$^3$ | 3 |
| **Экскаватор** | SDLG E6500F | 2.8 м$^3$ | 2 |

### 1.4.2 Туслах ажлын механикжуулалт

Мөргөцгийн хайлуур жоншны хүдрийн ил уурхайд ажиллах үндсэн тоног төхөөрөмжүүдээс гадна шимт хөрс хуулах, нөхөн сэргээлт, зам талбай засах, суваг шуудуу татах, засвар үйлчилгээний ажилд дараах туслах болон үйлчилгээний машин, тоног төхөөрөмжүүд ажиллана.

*Хүснэгт 10. Уурхайн туслах тоног төхөөрөмж*

| Тоног төхөөрөмж | Марк | Тоо, ш |
|---|---|---|
| **Үйлчилгээний машин** | Alphard | 1 |
| **Усны машин** | Howo336HP | 1 |
| **Шатахуун түгээх машин** | Tonley | 1 |
| **Бульдозер** | CAT D8T | 1 |
| **Утгуурт ачигч** | | 1 |

| | | |
|---|---|---|
| **Грейфер** | LIUGONG CLG4580 | 1 |

### 1.4.3 Өрөмдлөг, тэсэлгээ

**Өрөмдлөгийн ажил**

Бусад ажиллагаанууд өрөмдлөгөөс шалтгаалан зогсохгүй байх, өрөмдлөгийн бүтээл өндөр, өртөг зардал хямд байх нь өрмийн төхөөрөмжийн ажлын зохион байгуулалтын зорилго юм.

Өрмийн төхөөрөмжийг ажлын шинэ байршилд шилжүүлэх, талбай засах, гэрэлтүүлгийн зориулалтаар цахилгаан хангамжийг бүрдүүлэх, цооногийн байрлалын тэмдэглэгээ хийх зэрэг нь бэлтгэл ажиллагаанд хамаарна. Эдгээрийг аль болох богино хугацаанд хэрэгжүүлэх, зэрэгцүүлэн гүйцэтгэх нь чухал юм. Өрөмдлөгийн блок дахь ажиллагаа нь өрмийн төхөөрөмжийн ажиллагаатай холбоотой бөгөөд өрөмдөх технологийн дагуу хийгдэнэ. Нэгдүгээр эгнээний (доголын ирмэг талын) цооногийг өрөмдөхдөө өрмийн төхөөрөмж доголын ирмэгийн шугам эгц (90°) байрлалтай байх шаардлагатай.

**Тэсэлгээний ажил**

Чулуулгийн тэслэгдэх зэргийг тэсрэх бодисын жишиг хувийн зарцуулалтаас хамааруулж В.В.Ржевскийн баримтлалаар 5 ангилалд хуваана. Уг нөхцөлд хүнд өрөмдөгдөх, маш хүнд зэрэг тэслэгдэх ангилалд багтаж байна.

## 1.5 Дэд бүтэц

### 1.5.1 Уурхайн барилга байгууламж

**Уурхайн хотхон.** Уурхайн ажилчдыг уг тосгонд байрлуулан, өглөө оройны ээлжийн ажилчдыг автобусаар зөөвөрлөхөөр төлөвлөсөн. Уг тосгон нь ажилчдын амрах, ажиллах нөхцөл боломжийг хангасан амралтын байрууд, ажилчдын амрах байртай байна.

Уурхайн газрын дээрх барилга байгууламж, уурхайн удирдлагуудын контор буюу ажлын өрөө, нярадын байр буюу даалгавар авах өрөө, ажилчдын хувцас солих, усанд орох газар уурхайн ажиллагсдын цайны газар автомашины гараж, манаачийн байр, авто машины засварын газар зэрэг барилга байгууламж нь уурхайн тосгон дотор байрлана. Тэсрэх материал хадгалах агуулах, шатахуун түгээх станц нь уурхайн тосгон болон бусад барилга байгууламжаас аюулгүйн зайг тус тус харгалзан барьж байгуулахаар төлөвлөв.

**Тэсрэх материалын агуулах.** Уурхай нь ашиглалтын хугацаанд нийт 5105 тн тэсрэх бодис хэрэглэнэ. Тэсрэх бодисын жилийн дундаж хэрэглээ 237 тн байна. ТБ-ын агуулах нь 60 тн-ын багтаамжтай контейнор байх бөгөөд энэ нь уурхайн 2 сарын хэрэглээг бүрэн хангана. Тэсрэх материалын агуулахын барилгыг хамгаалалтад авч тэсрэх бодисыг ашиглах, хадгалах, түгээх, тээвэрлэх ажлыг ТБ - той харьцах норм дүрмийн дагуу явуулна. Тэсрэх бодисын агуулахыг аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу осол авааргүй зайд байрлуулж харуул хамгаалалтаар хангасан байна.

***Тэсрэх материалын агуулахыг байгуулах, ашиглах***

- Тэсрэх материалын агуулах нь тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 14.4-т заасны дагуу тогтоосон байршил, тусгайлан тоноглосон чингэлэг байна.

- Тэсрэх материалын агуулах дахь өрөө, тавиур тус бүрд тэсрэх материал, хэрэгслийн болон тэсэлгээний аппаратын нэр төрөл, тэдгээрийн тоо ширхэг, ачилтын дугаар үйлдвэрлэсэн он сар өдөр болон хадгалалтын хугацааг тус тус заасан товч тодорхойлолтыг өлгөсөн байна.
- Тэсрэх материалын агуулах нь тааз, хананаас бороо, цасны ус гоожихоос хамгаалсан агааржуулалт сайтай байх.
- Тэсрэх материалын байнгын агуулах тус бүрийн онцлогт тохирсон аваар ослын үед ажиллах төлөвлөгөө боловсруулна.

**Сэлбэг материалын агуулах.** Уурхайн тоног төхөөрөмжийн тоо, бүтцээс хамааруулан сэлбэг материалын агуулахын хэмжээг 150 $м^2$ хэмжээтэй байхаар бодож тусгалаа. Агуулахын барилга нь төмөр рам, хөөсөнцөр дулаалга бүхий хөнгөн материалаар хийгдэнэ.

### 1.5.2 Цахилгаан хангамж

Уурхайд дараах цахилгаан хэрэглэгчид байна.

- Гэрэлтүүлэг
- Засварын газар
- Кемп
- Агуулах

Уурхайн цахилгаан эрчим хүчээр хангах шаардлагатай объектуудыг цахилгаанаа хангахдаа уурхай нь дэд бүтэц, төвийн шугамаас зайтай байгаа учир дизель станцаар хангаж ажиллаж байна. Ил уурхайн цахилгаан хэрэглэгчид нь үндсэн тоног төхөөрөмжүүд, гэрэлтүүлэг, засварын газар, кемп, агуулах зэрэг байна

### 1.5.3 Дулаан хангамж

Тусгаарлагч хамгаалалт, дулаан шаардлагатай үйлдвэрийн зориулалт бүхий барилга байгууламж зэрэг нь бат бөх, тогтвортой байх шаардлагыг хангасан, галд тэсвэртэй, удаан хугацаанд ашиглах боломжтой, түүнчлэн архитектур, эдийн засаг, дулааны техникийн нормд бүрэн нийцсэн байна. Дулааны бүх хэрэглэгчид нь үйлдвэрлэлийн байгууламжаас бүрдэнэ. Дулааны горим дахь дулааны алдагдал нь дулааны урсгалын хэмжээгээр тодорхойлогдох ба барилга байгууламжийн хийц болон архитектур-төлөвлөлтийн шийдлээс хамаарна. Тус уурхайн дулаанаар хангах барилга байгууламжийг бага оврын нам даралтын уурын зуухаар хангах боломжтой байна.

### 1.5.4 Усан хангамж

Гурван хүлэгт хайлуур жоншны орд нь гидрогеологийн мужлалаар гидрогеологийн өмнөд системийн Умард говийн гүвээт-халхын дундад талын ай савд багтана.

Уурхайд дараах усны хэрэглэгчид байна.

- Тосгоны унд, ахуйн хэрэглээ
- Зам, талбайн тоосжилт дарах усалгаа
- Нөхөн сэргээлтийн усалгаа

## 1.6 Төслийн эцсийн бүтээгдэхүүн

### 1.6.1 Элементийн шинжилгээ, металлын баланс

Нэр- Хайлуур жоншны хүдэр

Марк- ХЖ-20-оос ХЖ-55

Олон улсын нэршил- FO

# 2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

## 2.1 Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

*Хүснэгт 11. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт*

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх урсцын өөрчлөлт | | | x | | x | | | | | |
| Гадаргын урсцын өөрчлөлт | | | x | | x | | | | | |
| Ургамлын бүтцийн өөрчлөлт | x | | | | x | | x | x | | |
| Хөрсний элэгдэл, эвдрэл | x | | | | x | | x | x | | |
| Геологийн тогтцын өөрчлөлт | x | | | | x | | x | x | | |
| Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт | | x | | | | | | | x | |
| Уур амьсгалын (бичил) өөрчлөлт | | | | | | | | | | |
| 2. Байгалийн нөөц ашиглалт | | | | | | | | | | |
| Газрын гадаргын нөөц баялаг | x | | | | x | | | | x | |
| Бэлчээрийн байдал | | | x | | x | | | | | |
| Эрдэс түүхий эдийн нөөц | x | | | | x | | | | x | |
| Эрчим хүчний нөөц | x | | | | x | | | | x | |
| 3. Байгаль, орчны өөрчлөлт | | | | | | | | | | |
| Газрын доорх усны чанар, хэмжээ | | | x | | x | | | | | |
| Гадаргын усны чанар хэмжээ | | | x | | x | | | | | |
| Агаарын бохирдол | | | x | | x | | | | | |
| Хөрсний бохирдол | | | x | | x | | | | | |
| Төслийн үйл ажиллагаанаас ялгарах бохирдуулагч бодис хүний эрүүл мэндэд нөлөөлөх | | | x | | x | | | | | |
| Дуу чимээ, шуугианы нөлөө | | x | | | x | | | | | x |
| 4. Байгалийн өнгө төрх, түүх, соёлын дурсгалт зүйл, археологи, палеонтологийн олдвор | | | | | | | | | | |
| Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх | x | | | | x | | | | x | |
| Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх | x | | | | x | | | | x | |
| Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх | | | x | | x | | | | | |
| Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх | | | x | | x | | | | | |
| Археологи, палеонтологийн олдворт нөлөөлөх | | | x | | x | | | | | |
| 5. Нийгэмд үзүүлэх нөлөө | | | | | | | | | | |
| Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх | + | | | | + | | | | + | |
| Үйлчилгээний салбарын ү/а-нд нөлөөлөх | | + | | | + | | | | | + |
| Хүн амын орлого өөрчлөгдөж, нэмэгдэх | + | | | | + | | | | + | |
| Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх | | | x | | x | | | | | |
| 6. Эдийн засагт үзүүлэх нөлөө | | | | | | | | | | |
| Татварын орлого өөрчлөгдөх | + | | | | + | | | | | + |
| Орон нутгийн орлого нэмэгдэх | + | | | | + | | | | | + |
| Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох | | + | | | + | | | | | + |
| Ажлын байр нэмэгдэх | + | | | | + | | | | | + |

| Байгаль орчны үзүүлэлт | Шууд | Шууд бус | Өөрөөр зохицуулагдах | Богино хугацааны | Урт хугацааны | Буцаж нөлөөлөх | Буцалтгүй нөлөөлөх | Хүчтэй | Дунд зэрэг | Бага зэрэг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх | + | | | | + | | | | | + |
| 7. Бусад нөлөөлөл | | | | | | | | | | |
| Бохир ус хөрсөнд нэвчиж, хөрс ба грунтын усыг бохирдуулах | | | x | | x | | | | | |
| Дүн | 14 | 4 | 13 | 0 | 30 | 0 | 3 | 3 | 8 | 7 |

Төслийн болзошгүй сөрөг болон эерэг нөлөөллийн хэлбэр, хугацаа, эрчмийн үндэслэлийг дараах байдлаар гаргасан болно. Үүнд:

*Шууд нөлөөлөл:*

- Ордын хувьд гурван өөр газар ил уурхайн олборлолт явуулах бөгөөд уурхай 1 нь 1200 метрийн төвшин хүртэл 75 м гүнтэйгээр, уурхай 2 нь 1205 метрийн төвшин хүртэл 74 м гүнтэйгээр, уурхай 3 нь 1255 метрийн төвшин хүртэл 30 м гүнтэйгээр тус бүр хүдрийн биетийн уналын дагуу дээрээсээ доош гэсэн ерөнхий чиглэлтэй, хүдрийн биетийн суналын дагуу уулын ажлын ахилттайгаар гүйцэтгэнэ үүнд нийт 2.3 мян.м$^3$ хөрс хуулагдаж 10.1 га талбай,, хөрсний овоолгод 17,1 га, шимт хөрсний овоолгод 1,7 га, түр овоолгод 1,18 га, уурхайн хотхон барилга байгууламжид 0,81 га, ШТС-ын зориулалтаар 0,2 га, засварын газарт 0,4 га, тэсрэх материалын агуулахад 0,8 га, зам талбайд 4,1 га талбай нийт 35.6 га талбай хөрс хуулалт барилга бүтээн байгуулалт, олборлолт зэргээс хөрсөн бүрхэвч ухагдаж, ургамлан нөмрөг талхагдаж урт хугацаанд шууд хүчтэй нөлөөлнө;
- Уурхайн олборлолтын ажлын улмаас геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр шууд урт хугацаанд дунд зэрэг нөлөөлнө;
- Орон нутгийн орлого, ажлын байр нэмэгдэх зэрэгт төслийн үйл ажиллагаа явагдах хугацаанд болон цаашид эергээр нөлөөлнө;

*Шууд бус нөлөөлөл:*

- Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд урт хугацаанд эерэг нөлөөлнө;
- Ордын олборлолтын үйл ажиллагааны үр дүнд дуу чимээ нь шууд бусаар урт хугацаанд сөргөөр нөлөөлнө;

*Богино хугацааны нөлөөлөл:*

- Төслийн үйл ажиллагааны явцад дуу чимээ, физик бохирдол тодорхой хугацаагаар ихэснэ.

*Хүчтэй нөлөөлөл:*

- Болзошгүй нөлөөллийн үнэлгээ хийх явцад төслийн зүгээс 35.6 га талбай хөрс хуулалт барилга бүтээн байгуулалт, олборлолт зэргээс хөрсөн бүрхэвч ухагдаж, ургамлан нөмрөг талхагдаж урт хугацаанд шууд хүчтэй нөлөөлнө хөрс болон ургамлан, геологийн тогтцод, байгалийн үзэсгэлэнт өнгө төрх, өөрчлөгдөх болон

ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх зэргээр хүчтэй сөрөг нөлөөлөл үзүүлж байна.

# 3. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХАМРАХ ХҮРЭЭ

**Зорилго:** Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх, стратегийн үнэлгээний зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, урьдчилан сэргийлэх, төсөл хэрэгжих орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх үндсэн зорилго бүхий эрхзүйн баримт бичиг юм.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай шинэчилсэн хуулийн 9-р зүйлд заасныар Байгаль орчны менежмент төлөвлөгөө (БОМТ) нь нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан баримт бичиг бөгөөд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ (БОННҮ)-ний салшгүй хэсэг юм.

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд болон хүний эрүүл мэнд, нийгэм эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулахад зайлшгүй хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөх;

Төслийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усан орчин болон ажлын байрны нөхцөлд хэрхэн нөлөөлж байгаа талаар хяналт шинжилгээ явуулах арга хэмжээг төлөвлөх;

Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт орших “Билгэх сайхан уул”” ХХК-ийн MV-022839 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Гурван хүлэгт хайлуур жоншны ордыг ил аргаар ашиглах төслийн БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” боловсруулсан болно.

Уурхайн Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний судалгаагаар тогтоогдсон гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, тухайн жилийн уурхайн ашиглалтын төлөвлөгөөтэй уялдуулсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжилтийг амжилттай биелүүлэн ажилласан. 2026 оны БОМТ-ний биелэлтийг Дундговь аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэгт үнэлүүлж 91.4%-ийн үнэлгээ авсан.

*Хүснэгт 12. 2026 онд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал*

| № | Ажлын нэр | Зардал, мян.төг |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | 2 500.000 |
| 2 | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө | 11.500,000 |
| 3 | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний зардал | 10.000,000 |
| 4 | Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох төлөвлөгөө | - |
| 5 | Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 6 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө | 1 275,000 |
| 7 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө | 2 500,000 |
| 8 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | 2 425.000 |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | - |
| 10 | Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | - |
| | **Нийт зардал** | **30,200,000** |

# 4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 13. Сөрөг нөлөөллийг бууруулах хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | **Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | | | |
| 1 | Орчны агаарын чанар хорт хий, хүнд металлаар бохирдох | Усан халаалтын зуухнаас агаарт ялгарах утаа бохирдлын хэмжээг тодорхойлуулах | УХЗ | тогтмол | - | - | Үйл ажиллагааны зардал | 2026 | Агаарын тухай хууль, MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага |
| 2 | | Суурин тоног төхөөрөмж генератор, УХЗ-ны төлөвлөгөөт засвар үйлчилгээг тогтмол хийх | Төсөлд хэрэглэгдэж буй Суурин тоног төхөөрөмж генератор, УХЗ | тогтмол | - | - | Үйл ажиллагааны зардал | 2026 | Ажлын байрны агаарын эрүүл ахуйн шаардлага: MNS 4990:2010, MNS 0017-2-3-16:1998 |
| 3 | Авто тээврийн хэрэгслээс тоосжилт, хорт хий ялгарах | Ил уурхайн ухаш, хүдрийн талбай, жонш ангилан ялгах талбай уурхайн хотхон,технологийн болон гадаад тээврийн замын тоосжилт болон дуу шуугианы хэмжилтийг хийх | Уурхайн ашиглалтын талбай болон тээврийн зам | тогтмол | - | - | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан | 2026 | MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага |
| | | Тээврийн хэрэгслийн хурдны хяналтыг мөрдөж ажиллах, хурд хязгаарлах тэмдэг тэмдэглэгээг засаж сайжруулж байх | Төслийн талбайд | Удаа | - | - | Засвар үйлчилгээний зардал үйл ажиллагааны зардлын | 2026 | MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | дүнгээр нэмэгдэнэ | | |
| 4 | | БОННҮ-д тусгасан технологийн болон гадаад тээврийн замаас үүсэх тоосжилтыг бууруулах арга хэмжээнүүдийг/тоос дарагч бодис, төхөөрөмж, усалгаа, ажлын талбай болон замыг урьдчилан бэлтгэх/ авч хэрэгжүүлэх салхи ихтэй хуурайшилттай үед онцгой анхааралтай нэмэлт арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх | Гадаад болон дотоод тээврийн зам, өрөмдлөгийн ажил явуулах талбай | Үйл ажиллагааны зардлаар тооцох | | | | Тасал хэрэгжих бүхий л хугацаанд | |
| | | Дүн | | | | | 0 | | |
| | | **Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | | | |
| 4 | | Унд ахуйн хэрэглээнд ашиглах усыг арвилан хэмнэх, ус хэмнэлтийн менежментийг хэрэгжүүлэх | Ус хэмнэх | ширхэг | - | Тогтмол | Үйл ажиллагааны зардал | 2026 | “Усны тухай хууль” Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль |
| 5 | | Цэвэр бохир усны шугам хоолойн гэмтлийг тогтмол шалгаж байх | Иж бүрэн | ширхэг | Үйлд ажиллагааны зардал | | | 2026 | MNS 6561:2015 MNS 4943:2015 MNS 6734:2018 |
| 6 | | Ус ашиглах дүгнэлт, гэрээг байгуулж ажиллах. Төсөл хэрэгжүүлэгч нь “Усны тухай хууль” –ийн 28.4 –р зүйлд заасныар “Ус ашиглах дүгнэлт” -ийг Усны газар, аймгийн байгаль орчны албанаас гаргуулна. Ус | Хаягдал бохир усны цоонг | удаа | Үйл ажиллагааны зардлаар | | | 2026 | “Усны тухай хууль” БОНХАЖ-ын сайд, БХБ-ын сайдын |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ашиглах дүгнэлтийг үндэслэн ус ашиглах зөвшөөрлийг Сумын Засаг даргатай холбогдох гэрээг байгуулж ажиллах шаардлагатай. | | | | | | | хамтарсан тушаал-А-230/127 тоот журам ,, |
| 7 | | Ус хангамжийн эх үүсвэрээс 50 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хориглолтын бүс, 200 метрээс доошгүй зайд эрүүл ахуйн хязгаарлалтын бүсийг тогтоож мөрдөж ажиллах | Төслийн талбай | удаа | Үйлд ажиллагааны зардал | | | 2026 | |
| 8 | Усны чанар | Бохир ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд хяналт тавьж тухайн байгууламж хариуцсан ажилтан тогтмол үзлэг хийх | Бохир ус зайлуулах цооног, түүнээс үүсэх бохирдлыг хязгаарлах | Иж бүрэн | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | БОАЖ-ын сайд, ЭМ-ын сайдын хамтарсан тушаал-А/82/128 тоот журам |
| 9 | | Бохир ус зөөвөрлөх машин чөлөөтэй орж гарах талбайтай байна. | | | | | | 2026 | |
| 10 | | Ус ашиглагч нь цэгийн эзлэхүүний 70-80 хувь дүүрсэн үед суллаж, цэг болон цэгийн орчинд халдваргүйжүүлэх үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжээр халдваргүйжүүлэлтийг хийлгэнэ. | | | | | | Улиралд 1 удаа | |
| | | **Дүн** | | | | | **0.0** | | |
| | | **Хөрс, газрын гадаргад үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | | | |
| 11 | Хөрсний бохирдол | Барилга байгууламжийн гадна талбайд ногоон байгууламжийг | Төслийн талбай | удаа | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | MNS 5850:2008, |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх, орчныг цэвэр байлгах | | | | | | | |
| 12 | | Тээврийн хэрэгслийн болон явган хүний зам, зогсоол засах тэмдэг, тэмдэглэгээ, хаалт хамгаалалтын засвар үйлчилгээг хийх | Төслийн талбай | удаа | Засвар үйлчилгээний зардаал | | | 2026 | “Хөрсний чанар, хөрс бохирдуулагч бодис,элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ |
| 13 | | Хөрсөн орчны мониторинг судалгааг хийх | Төслийн талбайн хөрс | удаа | - | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан | | 2026 | MNS 3297:1991, “Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ” |
| 14 | | Энгийн болон аюултай, ахуйн бохир ус зайлуулах гэрээг байгуулж зөвшөөрөгдсөн цэгт хаяж зайлуулах | Төслийн талбайд | Тогтмол | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | |
| 15 | | Авто машины зогсоол, засварын газар, ШТС орчим асгарсан тос, тосолгооны материалыг тухай бүрд нь цэвэрлэж авах | Төслийн талбайд | удаа | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | |
| 16 | | Тос тосолгооны хаягдлаар бохирдсон хөрсийг саармагжуулах талбай бэлтгэх | Төслийн талбайд | удаа | 2500,000 | | | 2026 | Газрын тухай хууль<br>“Газрын тухай” хууль<br>“Байгаль орчныг хамгаалах ухай” хуул:<br>“Газрын хэвлийн тухай” хууль |
| 17 | | Үржил шимт хөрсийг хуулж хуулж авсан шимт хөрсийг технологийн дагуу хадгалах | Хуулсан шимт хөрс | удаа | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | Газрын тухай хууль MNS 5916:2008 |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | “Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрсний хуулалт, хадгалалт” MNS 5917:2008 |
| 18 | | Олон салаа шороон зам үүсэх нөхцөлд хаах нөхөн сэргээх арга хэмжээ авах | Хөрсний элэгдэл, эвдрэлийн нөлөөллийн бүс | удаа | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | “Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” стандартууд |
| | | **Дүн** | | | | | **2 500.000** | | |
| | | **Биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ** | | | | | | | |
| 19 | Ургамал | Хөрс хуулалт хийгдэх үед ургамлын ажиглалт хийх, газар хөндөх зөвшөөрлийн хуудас хөтлөх | Төслийн талбайд | удаа | Нөхөн сэргээлтийн зардалд тооцогдсон | | | 2026 | Ургамал хамгааллын тухай хууль<br>Байгалийн ургамлын тухай хууль<br>MNS 5918:2008 “Эвдэрсэн газрыг ургамалжуулах. Техникийн ерөнхий шаардлага” |
| | | Ургамлын мониторинг судалгаа хийх | Төслийн талбайд | удаа | Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөнд зарим асуудал нь хамааралтай болно. | | | | |
| 20 | Амьтан | Уурхайн ухаш болон уурхайн талбайд зэрлэг амьтад болон мал амьтан унах, гэмтэхээс сэргийлж хил хязгаар тогтоосны дагуу хашаа хайс татах, шуудуу далан | Төслийн талбайд | ширхэг | Засвар үйлчилгээний зардлаар | | | 2026 | Амьтны тухай хууль |

| № | Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал (Төгрөг) | Тоо хэмжээ | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрхзүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | босгох гэрэл цацруулагч байршуулах, засвар үйлчилгээг хийх | | | | | | | |
| | | Ажилчдыг хууль бусаар ан хийхгүй байхыг анхааруулах, хяналт тавих | | | | | | | |
| | | **Дүн** | | | | | **0** | | |
| | | | | **Эрчим хүч** | | | | | |
| **21** | Цахилгаан эрчим хүчний хэрэглээ | Сэргээгдэх эрчим хүчийг илүүтэй сонгож хэрэглэх | Төслийн талбай | Иж бүрэн | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | |
| **22** | | Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмжийг сонгож хэрэглэх | Төслийн талбай | Иж бүрэн | Үйл ажиллагааны зардал | | | 2026 | |
| | | **Дүн** | | | | | **-** | | |
| | | **Нийт дүн** | | | | | **2 500.000** | | |

# 5. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Ил уурхайн ашиглалтын төлөвлөгөөгөөр ил уурхай, хөрсний гадаад овоолго, үржил шимт хөрсний овоолго, уурхайн хотхон, баяжуулах цех, авто зам зэрэг орно. Орд ашиглалтын 4 жилийн хугацаанд 36.61 га талбай эвдрэлд өртөхөөр байна. Төсөл хэрэгжүүлэгч нь хариуцлагатай уул уурхайг дэмжигч байгууллага болохоор ажиллаж байгаа бөгөөд уул уурхайн нөхөн сэргээлтийг Монгол улсын холбогдох хууль, эрх зүй, стандарт шаардлагуудад нийцүүлэхээс гадна тухайн бүс нутгийн цаг уурын онцлог, орчин нөхцөлд тохирсон, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн туршлага арга зүйд тулгуурлан гүйцэтгэх зарчим баримтлан ажиллаж байна.

*Хүснэгт 14. ТЭЗҮ-д тусгасан нөхөн сэргээлтийн ажлын төлөвлөлт*

| № | Хийгдэх ажил | Ажил хэрэгжих жилүүд |
|---|---|---|
| **Бэлтгэл ажил** | | |
| 1 | Байгаль орчны суурь төлөв байдлын шинжилгээний ажил | Эхний жил |
| 2 | Нөхөн сэргээлтийн ажлын төсөл боловсруулах | 3 дахь жилээс |
| **Байгаль орчныг хамгаалах** | | |
| 3 | Байгаль орчны хяналт | Жил бүр |
| **Техникийн нөхөн сэргээлтийн ажил** | | |
| 4 | Шимт хөрсийг хуулах ажил | Жил бүр |
| 5 | Шимт хөрсийг ачих, тээвэрлэх | Жил бүр |
| 6 | Хөрсний гадаад овоолгыг зөөж уурхайн ухашийг нөхөн дүүргэх | 3 дахь жилээс |
| 7 | Шимт хөрсөөр хучих ажлын ачилт | 3 дахь жилээс |
| 8 | Шимт хөрсөөр хучих ажлын тээвэрлэлт | 3 дахь жилээс |
| 9 | Тараасан хөрсийг бульдозероор тэгшлэх | 3 дахь жилээс |
| 10 | Тэгшилсэн хөрсийг нягтаршуулах | 3 дахь жилээс |
| 11 | Шимт хөрсийг хадгалах, хамгаалах | Жил бүр |
| **Биологийн нөхөн сэргээлтийн ажил** | | |
| 12 | Бүрхэвч ургамал тарих | 3 дахь жилээс |
| 13 | Олон наст ургамлын үр тарьж суулгах | 3 дахь жилээс |
| 14 | Мод тарих, /Усалгаа, арчилгаа, тордолт хийх/ | Жил бүр |
| **Хаалтын дараах хяналт-шинжилгээний ажил** | | |
| 15 | Нөхөн сэргээгдэж байгаа явцын хяналт-шинжилгээний ажил | Жил бүр |
| 16 | Мэргэжлийн байгууллагаар хаалтын төлөвлөгөө хийлгэх | 3 дахь жилээс |
| 17 | Уурхайн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн тээвэрлэлт | 4 дахь жилээс |

2026 оны хувьд 506,464 $м^3$ хөрс хуулахаар ТЭЗҮ-д тооцоолон тусгасан. Мөн шимт хөрсийг хадгалах хамгаалах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Шимт хөрсний овоолго 12.5 Үржил шимт хөрсийг хуулахдаа 0.3 метрээс ихгүй зузаантайгаар сийрэгжилтийн ажлыг хийлгүйгээр шууд бульдозероор түрж, утгуурт ачигчаар утган автосамосвалд ачин ил уурхайн үржил шимт хөрсний гадаад овоолгод байрлуулна. Шимт хөрсийг уурхайн талбайн гадна 150 170 м зайд байрлуулж байна.

Шимт хөрсний овоолгод түүсэн нутгийн ургамлын үрээр тариалалт хийх, туршилт судалгааны ажил хийх ажилд 1.500,000 төлөвлөлөв.

*Хүснэгт 15. 2026 онд хийж гүйцэтгэхээр ТЭЗҮ-д тусгасан ажлын төлөвлөгөө.*

| **№** | **Үндсэн үзүүлэлт** | **Хэмжих нэгж** | **2-р жил** |
|---|---|---|---|
| **1** | Уулын цул | $м^3$ | 550,261.4 |
| **2** | Хөрс | $м^3$ | 506,464 |
| **3** | Жонш | $м^3$ | 43,797.4 |
| **4** | | тн | 120,000.0 |
| **5** | Хөрс хуулалтын коэффициент | $м^3$/тн | 4,22 |


овоолго
Шимт хөрсний овоолго - 1
Шимт хөрсний овоолго - 2
Хөрсний овоолго - 1
Хөрсний овоолго - 2
1275
1308



*Зураг 5. Шимт хөрсний төлөвлөлт болон өнөөгийн төрх байдал*

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд төсөл хэрэгжүүлэгч “Билгэх сайхан уул” ХХК нь орон нутагт жил бүр 2000 мод тарихаар төлөвлөсөн байна.

“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөн, “Дундговио ногооруулъя” дэд хөтөлбөрийн хүрээнд ногоон байгууламжийг нэмэгдүүлэхэд сумын төвд 250 мод тарьж усалгаа арчилгааны зардалд хөрөнгө оруулж ажилласан ба энэ ажлаа үргэлжлүүлнэ хамтран ажиллана.

Орчны тохижилтын хүрээнд 250 ширхэг модыг уурхайнд тариална.

Мөн уурхайн эвдрэл тэлэлтийг мэргэжлийн байгууллагаар маркшейдрийн хэмжилт хийлгэх ба нөхөн сэргээлтийн төлөвлөгөө боловсруулах ажилд 10.000,00 төгрөг төсөвт суулгав.

# 6. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг уурхайн 2 дах жилээс хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөсөн бөгөөд 2026 оноос уурхай төсөл хэрэгжиж эхэлж байгаа бөгөөд мэргэжлийн байгууллагаар “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах судалгаа төлөвлөгөөг боловсруулахаар 10,0 сая төгрөгийг төсөвлөсөн ба сонгон шалгаруулалт зарлан сонгож ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг энэ оноос төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийж гүйцэтгэж эхлэнэ.




*Зураг 6. Нөөлөллийн тархалтийн хэмжээ болон дүйцүүлэн хамгаалах боломжит газрын байршил*

# 7. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хайлуур жоншны ордын ашиглалтын талбайд ямар нэг барилга байгууламж, айл, айлын өвөлжөө, хаваржаа байхгүй бөгөөд нүүлгэн шилжүүлэх болон, нөхөн олговор олгох арга хэмжээ хийгдээгүй болно.

Гэсэн хэдий ч цаашид нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговортой холбоотой асуудал гарвал газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд: Үндсэн хууль (1992), Газрын тухай хууль (2002 нэмэлт өөрчлөлт 2017.06.09), Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003, нэмэлт өөрчлөлт 2017.02.02), Иргэний тухай хууль (2002, нэмэлт өөрчлөлт 2017.05.18) зэрэг болно.

## 8. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 16. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө*

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1 | Археологийн дурсгал | Хэрэв уурхайн үйл ажиллагааны үед Археологийн болон палеонтологийн ховор түүхийн дурсгалт олдворууд гарч ирвэл төрийн холбогдох байгууллагуудад заавал мэдэгдэх ёстой. | Уурхайн ашиглалтын нийт талбайн хэмжээнд | - | Тухайн үед нь шийдэх | | Үйл ажиллагааны турш | Соёлын өвийг хамгаалах тухай хууль /2014 оны 05 сарын 15-ны өдрийн шинэчилсэн найруулга/ , Бусад холбогдох салбарын яамнаас гаргасан дүрэм журмууд |
| 2 | Палеонтологийн дурсгал | | | | | | | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | **Нийт дүн** | **-** | | |

# 9. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

*Хүснэгт 17. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө*

| Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Байгалийн аюул гамшиг** | | | | | | | |
| **Байгалийн давтагдашгүй хүчин зүйл болох** | Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар мэдээлэл ажилчдад өгөх, урьдчилан сэргийлэх зөвлөмж гаргах | | 1 | 100.000 | 100.000 | 2026 | Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003- (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012.05.17) |
| **Нийт** | | | | | 100.000 | | |
| **Галын аюул** | | | | | | | |
| **Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагаар хангаагүйгээс галын аюул гарах** | Гал түймэр гарахаас урьдчилан сэргийлэх, гал түймэр гарсан тохиолдолд түүнийг шуурхай унтраах багаж хэрэгслийн иж бүрдлийг бэлэн байлгах; | Галын аюул эрсдэл | 2 | 500.000 | 1000.000 | 2026 | MNS 5390:2004, ХААЭА. Цахилгааны галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага<br>Галын аюулгүй байдлын тухай хууль, /шинэчилсэн найруулга/<br>Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль<br>MNS 5566:2005 Гал түймрээс хамгаалах, аж ахуйн нэгж байгууллага, барилга байгууламжид гал унтраах анхан шатны багаж хэрэгслийн зайлшгүй байх шаардлага, норм MNS4244-94 Галын аюулгүй байдлын ерөнхий шаардлага |
| | Онцгой байдлын газраас галын дүгнэлт гаргуулах | Галын аюул эрсдэл | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | | 2026 | |
| **Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар** | | | | | | | |
| **Төслийн үе шатанд хүний** | Уурхайн ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт семинарыг тогтмол зохион байгуулах, хамруулах | Төслийн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | | 2026 | MNS 4968:200“ХААЭА. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тавих ерөнхий шаардлага” |

| Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл | Урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Тоо хэмжээ | Нэгжийн зардал мян.төг | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа, давтамж | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|
| **эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлөх** | Уурхай нь өөрийн онцлогт тохирсон “Аваар устгах төлөвлөгөө боловсруулах заавар"-ын дагуу боловсруулсан аваар устгах төлөвлөгөөний дагуу ажиллах | Төслийн талбайд | - | - | - | 2026 | MNS 4995:2000, “ХААЭА. Доргио хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”<br>MNS 5002:2000, “ХААЭА. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага”<br>MNS ISO 13688:2000, “ХААЭА. Хамгаалалтын хувцас. Ерөнхий шаардлага”<br>MNS 5010:2001, “ХААЭА. Ажлын байран дахь тоосны агуулгыг хэмжихэд тавигдах ерөнхий шаардлага”<br>MNS 5105:2001, “ХАБ. Үйлдвэрлэлийн эрүүл ахуй. Эрүүл ахуйн хамгаалалтын бүсийн хэмжээ, ерөнхий шаардлага”<br>MNS ILO OSH 1:2003, “ХААЭА-н удирдлагын тогтолцооны талаарх удирдамж”<br>Хөдөлмөр аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль |
| | Болзошгүй осол, хүний амь насанд аюул учруулж болох нөхцөлүүдээс урьдчилан сэргийлэх | Төслийн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | | | |
| | Болзошгүй аваар ослын үед яаралтай хэрэглэх анхны тусламжийн багаж хэрэгсэл, эм тариаг бэлэн байлгах | Төслийн талбайд | 5 | 35000 | 175.000 | 2026 | |
| | Ажилтан бүрийг хөдөлмөр хамгаалах хэрэгслээр хангах | Төслийн талбайд | Үйл ажиллагааны зардалд тусгагдсан | | | | |
| | Болзошгүй осол аюулын үед орон нутгийн эмнэлэг болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах талаар тохиролцож гэрээ байгуулж ажиллах | Төслийн талбайд | Гэрээний үнийн дүнгээр | | | | |
| | **Нийт зардал мян. төг** | | | **1.275,000** | | | |

## 10. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хатуу, шингэн хог хаягдал нь хүн ам, үйлдвэрлэлд хэрэгцээт газрын нөөцийг багасгах, хөрс, ус, агаарыг хорт бодис, хүнд металл, нян вирусээр бохирдуулагч гол эх үүсвэр болдог. Хатуу хог хаягдал нь удаан задарч бодисын эргэлтэнд аажмаар орох ба задрах хугацаа нь удаан байдаг учраас байгаль орчинд хор хөнөөлтэй. Хог хаягдлыг энгийн, ахуйн, аюултай гэх мэтээр Монгол улсын Хог хаягдлын тухай хуульд заасан бөгөөд эдгээрийг хэлбэрээр нь хатуу, шингэн, хийн гэж ангилав.

- Энгийн хог хаягдал гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг хэлнэ.
- Ахуйн хог хаягдал гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг хэлнэ.

Энэхүү БОННҮ-ний тайлангийн 4.8.2-т хог хаягдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийн авна уу. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн үзэл баримтлал, зүйл заалтыг үндэслэн боловсруулав.

*Хүснэгт 18. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө*

| Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан, ялгах, хог хаягдлыг дахин ашиглах** | Хог хаягдал ангилан ялгаж хаях зориулалттай хогийн савнуудыг уурхайн, захиргаа, цайны газар зэрэг шаардлагатай газруудад нэмэлтээр тавих хуучин хогийн савнуудыг засварлах | Энгийн хог хаягдлаас үүсэх нөлөөллийн бүс | удаа | 50.000 | 10 | 500.000 | 2026 | Хог хаягдлын тухай хууль; БОАЖ-ын сайдын А/433 тушаал “Ариун цэврийн тухай” хууль; БОАЖ-ын сайдын 2017 оны А/349 тушаал Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл; БОАЖ-ын сайдын 2017 оны А/368 тушаал Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал; БОАЖ-ын сайдын 2018 оны А/18 тушаал Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах; |
| | Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахивар авах аж ахуйн нэгжид хүргүүлэх | | Удаа | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | | 2026 | |
| | Энгийн хог хаягдал үүсгэгч нь хог хаягдлын мэдээ тайланг тогтмол, заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлнэ. | | удаа | | | | 2026 | |
| **Хог хаягдлаас ялгарах үнэр, амархан муудаж ялзрах бусад хүнсний хаягдал зэргээс** | Хог хаягдал түр хадгалах талбайг шинэчлэн байгуулан тохижуулах нэвчилт явагдахааргүй, ирмэг хөвөө бүхий цементэн суурьтай болгон тохижуулах | Хог хаягдлын цэг | Удаа | - | 1 | 2000.000 | 2026 | |
| | Хуванцар сав, шил, лааз, дугуй, модны хаягдал, автомашины сэлбэг, төмрийн хаягдал, цаасны хаягдал гэх мэт дахин | Энгийн хог хаягдал | Удаа | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | | 2026 | |

| Хог хаягдлын ангилал | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | Нэгжийн зардал мян.төг | Тоо хэмжээ | Нийт зардал, мян.төг | Хэрэгжүүлэх хугацаа | Баримтлах эрх зүйн баримт бичиг |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| **халдварт өвчин тархах** | ашиглах, дахин боловсруулах боломжтой хаягдлуудыг нэг дор цуглуулж хуримтлуулах, боломжтой бол хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах | | | | | | | БОАЖ-ын сайдын 2018 оны А/443 тушаал Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах,тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага; БОАЖ-ын сайдын 2018 оны А/445 тушаал Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар; БОАЖ-ын сайдын 2018 оны А/21 тушаал; MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага; |
| | Хөрс шатах тослох материалаар бохирдсон тохиолдолд бохирдсон хэсгийг ялган авч саармагжуулах талбайд саармагжуулах | Төслийн талбай | Иш бүрэн | Үйл ажиллагааны зардал | | | 2026-2029 | |
| | Хатуу хог хаягдлыг зориулалтын битүүмжилсэн саванд хадгалж, байгаль орчны болон эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байгууллагын тогтоосон цэгт зайлуулж байх | Төслийн талбайд | Удаа | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | | 2026 | |
| **Аюултай хог хаягдал болон шатах тослох материалаар хөрс, газрын доорх ус бохирдож болзошгүй** | Аюултай хог хаягдлын Ү дугаар авах | Аюултай хог хаягдал | Удаа | Уурхайн дотоод төлөвлөлтөөр | | | 2026 | |
| | Үйл ажиллагаанаас гарсан ажилласан тос тосолгоо, шатах тослох материалыг тусгайлан битүүмжлэл сайтай саванд хуримтлуулан хаягдал тос боловсруулах тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан зайлуулах | Аюултай хог хаягдал | Удаа | | | | 2026 | |
| | **Нийт зардал мян. төг** | | | | | **2,500.000** | | |

## 11. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Билгэх сайхан уул” ХХК -аас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр нь байгаль орчныг хамгаалан төлөвлөгөөтэй нягт уялдсан бөгөөд байгаль орчныг хамгаалахаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнг илэрхийлж, уг авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ үр ашигтай байгаа эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүдэд юуг анхаарах шаардлагатайг зааж өгнө.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Билгэх сайхан уул” ХХК батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 11 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага /Байгаль орчин, аялал жуулчлалын яам/-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийг бүрэн хэрэгжүүлэх, батлагдсан арга, аргачлалаар дээжлэлт, хэмжилт хийх, холбогдох нарийвчлал, тохиргоог хангасан багаж тоног төхөөрөмжөөр шинжилгээг хийлгэх, үр дүнг шаардагдах нэгжийн системээр гаргах зэрэг бүхий л үйл ажиллагааг “Билгэх сайхан уул” ХХК хариуцах болно. Байгаль орчны хяналт шинжилгээг тус төслийн байгаль орчны хэлтсийн холбогдох ажилтнууд хариуцан гүйцэтгэх бөгөөд шаардлагатай тохиолдолд гаднаас мэргэжлийн байгууллагуудыг татан оролцуулна.

*Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр*

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хяналтын цэгийн байршил | Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, мян. төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| | | | Агаарын чанар | | | |
| **$CO_2$, $NO_2$, $SO_2$ Тоос нийт (PM10, PM2.5)** | Төслийн талбайд орчим-3 цэг | Жилд 2 удаа | 3 цэгт 2 удаа | 50,000 төг* 6* | 300.000 | - MNS 4585:2016 Агаарын чанар. Техникийн шаардлага<br>- MNS 5002:2000 |

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хяналтын цэгийн байршил | Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, мян. төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| | Баяжуулах үйлдвэр<br>Хаягдлын сан<br>Бутлуурын хэсэг | | | | | |
| **Дуу шуугиан хэмжээ** | Төслийн талбай орчимд-2 цэг<br>Баяжуулах үйлдвэр | | 2 цэгт<br>2 удаа | 25,000 төг*4* | 200.000 | |
| **Хөрс** | | | | | | |
| **Хөрсний агрохимийн үзүүлэлт** | Төслийн талбайн эрүүл газрын хөрснөөс- 2 цэг | Жилд<br>2 удаа | 2 цэгт<br>2 удаа | 50,000 төг*4 | 200.000 | - (MNS 3297-1991) Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм, хэмжээ стандарт<br>- MNS 5850:2019 Хөрсний чанар. Хөрсөнд агуулагдах бохирдуулах бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ. |
| **Орчны хөрсөн дэх эмгэг төрүүлэгч бактерийн тоо** | Хог хаягдлын цэг-1 | Жилд<br>1 удаа /дулааны улиралд/ | 1 цэгт<br>1 удаа | 25,000 төг*1 | 25.000 | |
| **Хөрсний хүнд металлууд (Ni, Cd, Pb, Cu, Zn, Cr гэх мэт)** | Төслийн талбайн шимт хөрсний овоолго, хүдрийн овоолго, хогийн цэг, Баяжуулах үйлдвэр орчмын хөрснөөс-4 цэг | Жилд<br>2 удаа | 4 цэгт<br>2 удаа | 50,000 төг*8 | 400.000 | |
| **Усны чанар** | | | | | | |
| **Ерөнхий хими, бактериологи** | Унд ахуйн ус-1 цэгт | Жилд<br>4 удаа | 1 цэгт<br>4 удаа | 75,000 төг*4 | 300.000 | - MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ<br>- MNS 4943:2015 Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. |

| Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт | Хяналтын цэгийн байршил | Хугацаа давтамж | Давтамжийн тоо | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, мян. төг | Баримтлах стандарт, арга, аргачлал |
|---|---|---|---|---|---|---|
| **Усны түвшин усны ундарга, нөөц** | Ус ашиглалтаас, зарцуулалтаас газар доорх усны горим өөрчлөгдөх | | | | | - |
| | | | Ургамлан нөмрөг | | | |
| **Ургамал устах, өсөлт ургалт нь саатах, төрөл зүйл өөрчлөгдөх, бүрхэц, биомасс багасах** | Төсөл хэрэгжиж буй талбай болон түүний ойр орчимд Ургамлын тусгаг бүрхэц, ургацын хэмжээ | Жил бүр | 1 | 1000.000 | 1000,000 | - |
| **Нийт зардал мян. төг** | | | | | **2.425.0000** | |




*Зураг 7. Төсөл хэрэгжүүлэгчид зөвлөж буй Мониторингийн цэг*

## 12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагааны туршид байгаль орчинд хамгийн бага сөрөг нөлөөгүй үйл ажиллагаа явуулах үүрэг хүлээж, мэргэжлийн боловсон хүчнээс бүрдсэн байгаль орчны асуудал хариуцсан байгаль орчны алба байгуулах ба төслөөс үзүүлж байгаа сөрөг нөлөөллүүдийг бууруулах, арилгах, байгаль орчныг хамгаалах арга хэмжээ авч ажиллах боловч төслийн удирдлагын хэмжээнд онцгойлон анхаарч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байна.

*Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө*

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | 2026 он | | | | |
| | | | Сар | Сар | Сар | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх | Тохиролцох | Сар 1 удаа | | | Уурхайн удирдлага | - |
| 2 | Байгаль орчны аудит | Гэрээний үнийн дүнгээр | 8 сар | | | Уурхайн удирдлага | - |
| 3 | Усны нөөц ашигласны төлбөр төлөх | Үйл ажиллагааны зардал | | | 10-р сар | Уурхайн удирдлага | - |
| 4 | Хаягдал усны дүгнэлт гаргуулах | Үйл ажиллагааны зардал | | | 10-р сар | Уурхайн удирдлага | - |
| 5 | Эвдэгдсэн талбайн хэмжээг мэргэжлийн эрх бүхий байгууллагаар хэмжүүлэх | Үйл ажиллагааны зардал | | | 10-р сар | Уурхайн удирдлага, уулын инженер | - |
| 6 | Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах | Үйл ажиллагааны зардал | 4 сар | 9-р сар | | Уурхайн удирдлага, Уурхайн БО-ны мэргэжилтэн | - |
| | Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх. | Үйл ажиллагааны зардал | | 11-р сар | | Уурхайн БО-ны мэргэжилтэн | - |
| | **Нийт** | **-** | | | | | |

## 13. ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ, ХЭЛЭЛЦҮҮЛЭХ

**Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх.** Хайлуур жоншны ордыг ашиглах төсөл нь Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутагт хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр дүүргийн удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

*Хүснэгт 21. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь*

| БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|
| **Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага** | Тайлан хүргүүлж тайлагнах | БОМТ-ний хэрэгжилтийн талаар | Жил бүрийн 11 сард | - | БО-ны мэргэжилтэн | БОУАӨЯ, БОГазар |
| **Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч,**<br>**Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага** | Танилцуулж, тайлагнах | Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар | Хагас жил тутам буюу 6, 11 сард | - | БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер | Засаг даргын тамгын газар |
| **Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч,**<br>**Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага** | Тайлагнах | Үйл ажиллагааны явцад түүхт дурсгалт зүйлс болон соёлын олдвор олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авсан талаар | Тухай бүрд | - | БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер | Засаг даргын тамгын газарт |
| **Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд** | Тайлагнах | Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах | Тухай бүрд | - | БО-ны мэргэжилтэн, үйл ажиллагааны менежер | Иргэдэд |

| БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд | Тайлагнах хэлбэр | Мэдээллийн агуулга | Зохион байгуулах хугацааны тов | Тайлагнах зардал, мян.төг | Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан | Зохион байгуулах газар |
|---|---|---|---|---|---|---|
| | | зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх; | | | | |
| **Нийт зардал мян. төг** | | | | - | | |